



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2018-02-28 № 06/22  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Ч.Эрдэнэбаатар* Ч.ЭРДЭНЭБААТАР

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХЭНТИЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР  
ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ  
САНГИЙН 2017 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

ТАБ-ын Тэргүүлэх аудитор  
Утас: 70562112  
Цахим хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 70562147  
Цахим хаяг:

Ахлах аудитор: Б.Наранцэцэг  
Утас: 70562147  
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг  
Байршил: Хэнтий аймаг Хэрлэн  
сум 3-р баг АЗДТГ-ын байр  
Цахим хуудас:  
Khentii@audit.gov.mn

2018 оны 02 дугаар сар

## Аудитын тайлан

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

## АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

### 1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /ХЭА-2018/ 1 /СТА-ЗГТС / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25 -наас 2018 оны 02 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын ахлах аудитор Б.Наранцэцэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2018 оны 02 дүгээр сарын 05-нд ТАБ-д ирүүлсэн байна.

ТАБ аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25 -наас 2018 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 25-нд байгууллагын удирдлагад гардуулна.

## **2.Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

## **3.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Хэнтий аймгийн Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь “Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол сургалт, жижиг аж ахуйн үйлдвэрийг дэмжих замаар орон нутагт бий болгох ажлын байрыг дэмжих үйлчилгээг иргэн, аж ахуй нэгж байгууллагад

9

чанартай хүртээмжтэй, шуурхай үзүүлэх" гэж байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасны дагуу Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг Хөдөлмөр нийгэм хамгааллын яамнаас аймгийн төрийн сангаар дамжуулан олгож байна

Төсвийн тухай хуулийн 16.5 дугаар зүйлд "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасан байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиуд бүрэн хэрэгжиж байна. Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

#### **4.Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын горим, нарийвчилсан сорил 13 -г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн сан нь санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

10

## 5. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байгаа бөгөөд байгууллагын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед "их" гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

## 6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу аймгийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

ХЭДС-аас Хэнтий аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2017 онд 1024.5 сая төгрөгийн урсгал санхүүжилтийг хуваарилж, ХБИ ажиллуулаагүй төлбөрийн орлого 1.5 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөөс 197.0 сая төгрөг, өмнөх оны үлдэгдэл 2.8 сая төгрөг буюу нийт 1225.8 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Үүнээс төсөл хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалд 1024.6 сая төгрөгийг олгосон байна.

## 7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд 2017 оны сангийн үйл ажиллагаа, төсөв хөрөнгийн талаарх мэдээллийг бүрэн байршуулж ажилласан байна.

## 8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 5 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй, сургалтын арга хэмжээний зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байна.

## 9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. ЛАБ-СТА-В-3/

## 10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй байна. Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах 3 хоногийн сургалтад оролцсон 27 мэргэжилтэн тус бүрт 1 боодол бичгийн цаас, принтерийн хор олгож, нийт 1.3 сая төгрөгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан. Энэ нь төсвийн тухай хуулийн 16.5.5, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23.1 дэх заалтыг тус тус зөрчиж, "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23.1 дэх заалтыг мөрдөж ажиллан, дотоод хяналтыг сайжруулах талаар зөвлөмж өгөх

2. Өмнөх оны аудитаар НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөх гэсэн зөвлөмж өгсөн боловч бүрэн хэрэгжүүлээгүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 18.2 дах заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулж, баталгаажуулан мөрдөж ажиллах зөвлөмж өгөх.

#### **11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Аудитын явцад залруулах материаллаг бус алдаа тогтоогдоогүй болно.

#### **12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

#### **13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй байна.

#### **14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1.3 сая төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрсэн ба дээрхи алдаа зөрчлийг давтахгүй байх зөвлөмж өгөв.

#### **15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2016 оны санхүүгийн тайланд "Өндөрхаан итгэл -Аудит" ХХК аудит хийсэн ба зөрчилгүй санал дүгнэлт өгсөн Аудитаар 4 зөвлөмж өгөгдсөн ба тус байгууллага нь зөвлөмжийн биелэлтийг гаргаж, албан бичгээр ирүүлсэн байна.



16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.


Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас, хавсралтууд 4 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

**Аудитын тайланг**

**Хянасан:**

Дарга, Тэргүүлэх аудитор

Аудитын менежер



/ Ч.Эрдэнэбаатар/

/ Д.Оюунтуяа/

**Бэлтгэсэн:**

Ахлах аудитор

/ Б.Наранцэцэг/

Огноо: 2018.02.26



Хэнтий аймаг дахь Төрийн  
аудитын газар

ХЭНТИЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ  
ДЭМЖИХ САНГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН

## Менежментийн захидал

### Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

НББ-ийн бодлогын баримт бичгийн талаар ...3

Асуудал 2

Зардлын талаар . . . . . 4

## Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хэнтий аймгийн ХЭДС-ийн дарга, нягтлан бодогч нарт талархал илэрхийлье.

### АГ-ын ажиглалт

Өмнөх оны аудитаар НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөх зөвлөмж өгсөн боловч бүрэн хэрэгжүүлээгүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 18.2 дах заалттай нийцэхгүй байна.

### АГ-ын зөвлөмж

1.НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулж, баталгаажуулан мөрдөх

### Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

### Төсвийн захирагчийн хариу

**АГ-ын ажиглалт**

Хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах 3 хоногийн сургалтад оролцсон 27 мэргэжилтэн тус бүрт 1 боодол бичгийн цаас, принтерийн хор олгож, нийт 1.3 сая төгрөгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан.

**АГ-ын зөвлөмж**

1.ХЭДС-ийн хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23-1- т заасан зориулалтын дагуу үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах

**Эрсдэлүүд**

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх


**Төсвийн захирагчийн хариу**

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ**

**ХЯНАСАН:**

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Д.ОЮУНТУЯА

**БЭЛТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР

Б.НАРАНЦЭЦЭГ

Огноо: 2018.02.26